



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/80

Мөрөн сум

Бага насны хүүхдийн цогц хөгжлийг
дэмжих орон тооны бус зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээ, төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулан ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ш.Отгон-Эрдэнэ), Эрүүл мэндийн газар (М.Мөнх-Аюуш), Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар (Ч.Дашбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих стратеги” боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг томилсон аймгийн Засаг даргын 2016 оны А/495 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 27-ны
өдрийн 4/80-р захирамжийн хавсралт

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга

-Аймгийн Засаг даргын орлогч

Зөвлөлийн гишүүд

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсрол, шинжлэх ухааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

-Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-Нийгмийн бодлогын хэлтсийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн

-Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан ахлах арга зүйч

-Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

-Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга

-Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл)

-Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга (2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл)

-Эрүүл мэндийн газрын дарга (2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл)

_____оОо_____